



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон нийт 20,448,500.00 (хорин сая дөрвөн зуун дөчин найман мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий 4 ширхэг автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярцогт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Акталж, данснаас хасаж сэлбэгээр худалдсан автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГӨЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ



000149

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн
 157 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
 АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Явсан км	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	УАЗ фермер, 53-96 УБН, тусгай, NHW1000227739	2005/2007	223,326	8,787,500.00	8,787,500.00	-
2	Мицубиши Пажеро, 68-79 УБВ, суудлын, JMAONY430YJ000150	2000/2007	310,400	9,361,000.00	9,361,000.00	-
3	Мотоцикль Мустанг-5, LXYPML09BO3977158, BG055926	2011	-	1,150,000.00	1,150,000.00	-
4	Мотоцикль Мустанг-5, LXPGML04BO3726600, BG051526	2011	-	1,150,000.00	1,150,000.00	-
Нийт дүн				20,448,500.00	20,448,500.00	-
				(хорин сая дөрвөн зуун дөчин найман мянга таван зуун)		